



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/494

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд баригдсан Сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Н.Шинэбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Анхбаяр	(Боловсролын ерөнхий газрын хяналтын инженер)
Г.Золбоо	(Барилгын хөгжлийн төвийн ББЗХ Хэлтсийн хяналтын инженер)
Д.Тулга	(Барилгын хөгжлийн төвийн ББЗХ Хэлтсийн хяналтын инженер)
О.Бадраа	(Боловсролын газрын дарга)
Д.Сандагдорж	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитекторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Д.Мягмарсүрэн	(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга техник хяналтын улсын байцаагч)
Г.Ням-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)
Л.Бямбасүрэн	(Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа)
Д.Өлзийсайхан	(Байгаль орчин аялал жуулчлалын газрын агаар орчны бохирдол хог хаягдал хариуцсан мэргэжилтэн)
Д.Аюушжав	(Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

А.Ганхуяг ("Стийл проект" ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Ганзориг ("Зоос импекс" ХХК-ийн менежер)
Т.Бат-Орших ("Зоос импекс" ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Д.Бүрэнчөдөр (Улаан-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга)
М.Батцогт (Улаан-Уул сумын Засаг даргын тамгын газрын дарга)
А.Нансалмаа (Улаан-Уул сумын сургуулийн захирал)
Б.Болдцэцэг (Улаан-Уул сумын сургуулийн нягтлан бодогч)
С.Шинэмонгол (Улаан-Уул сумын сургуулийн сантехникч)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)


2.Барилга байгууламжийг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Н.Шинэбаяр)-д даалгасугай.

3.Барилга байгууламжийг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ